



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

“Богд банк” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1.“Богд банк” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 1,600 (нэг мянга зургаан зуу) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 62,500,000 (жаран хоёр сая таван зуун мянга) ширхэг энгийн хувьцааг 20 хувааж нэг бүр нь 80 (ная) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,250,000,000 (нэг тэрбум хоёр зуун тавин сая) ширхэг энгийн хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар (Б.Дөлгөөн)-т, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д тус тус үүрэг болгосугай.

2.“Богд банк” ХК-ийн хувьцааг хуваахтай холбоотой ажиллагааг ажлын 10 өдөрт багтаан гүйцэтгэж, холбогдох тайланг ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК (Х.Алтай), “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д тус тус үүрэг болгосугай.

3.Компанийн хувьцааг хуваасантай холбогдуулан шинэчилсэн дүрмийг холбогдох журмын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Богд банк” ХК (Г.Саруул)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518000101